

**“ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН  
ЯАМ”-НЫ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ЗАВХАН АЙМГИЙН  
УЛИАСТАЙ СУМЫН “АЙМГУУДЫН БОХИР УС ЦЭВЭРЛЭХ  
БАЙГУУЛАМЖИЙГ ӨРГӨТГӨН ШИНЭЧЛЭХ, ШИНЭЭР  
БАРИХ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН  
ТАЙЛАН**



**УЛААНБААТАР ХОТ 2025 ОН**

## АГУУЛГА

|                                                                                                                                              |    |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| 1. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА                                                                                    | 3  |
| 1.1. Төслийн нэр                                                                                                                             | 3  |
| 1.2. Төсөл хэрэгжүүлэгч                                                                                                                      | 3  |
| 1.3. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байршил                                                                                                 | 3  |
| 1.4. Төслийн дэд бүтцийн төлөвлөлт                                                                                                           | 3  |
| 1.5. Төслийн хүчин чадал                                                                                                                     | 4  |
| 1.6. Төслийн газрын өнөөгийн байдал                                                                                                          | 7  |
| 1.7. Төсөл хэрэгжих газарт орчны хяналт шинжилгээний ажлын<br>хүрээнд хийсэн орчны хээрийн судалгаа                                          | 7  |
| 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br>БИЕЛЭЛТ                                                                        | 18 |
| 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ                                                                                   | 20 |
| 4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ                                                                                    | 21 |
| 5. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ                                                                                        | 21 |
| 6. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ                                                                                          | 22 |
| 7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ                                                                                             | 24 |
| 8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ<br>ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ                              | 26 |
| 9. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br>ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ<br>ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ | 26 |
| Дүгнэлт                                                                                                                                      | 27 |
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хавсралтууд                                                                            | 28 |


## 1. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**1.1. Төслийн нэр:** Завхан аймгийн Улиастай сумын “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төсөл

**1.2. Төсөл хэрэгжүүлэгч:** “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам”-ны “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төслийг хэрэгжүүлэх нэгж


**1.3. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байршил:**

Завхан аймгийн Улиастай сумын бохир ус цэвэрлэх байгууламж барихаар олгогдсон газар нь аймгийн төвөөс баруун урд зүгт байрлаж буй хуучин бохир ус цэвэрлэх байгууламжийн хойд талд байрлана.



Зураг 1. Төсөл хэрэгжих газрын байршлын зураг

**1.4. Төслийн дэд бүтцийн төлөвлөлт:** Төлийн дэд бүтэц, инженер хангамжийн хувьд төвлөрсөн ба бие даасан холимог шийдэлтэй байна.



**1.5. Төслийн хүчин чадал:** Төслийн төлөвлөлтөнд тусгасанаар Улиастай сумын ахуйн хэрэгцээнээс гарсан бохир ус болон түүнтэй ойролцоо найрлагатай үйлдвэрийн бохир усыг цэвэрлэхэд зориулагдана. Бохир ус цэвэрлэх байгууламжийн хүчин чадал нь 3000м<sup>3</sup>/хоног байна.

### 1.6. Төслийн газрын өнөөгийн байдал

Цэвэрлэх байгууламжийн барилгын газар шороо болон барилга угсралтын ажлын үед газар, түүний хэвлий хөндөгдөж, талбайн хил доторх хөрс, ургамлан нөмрөг эвдрэлд өртөх, барилгажилтын талбайн хилээр ургамлан нөмрөг талхагдсан байна. Үүнийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд жил бүр байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд суурь судалгааг хийж, тухай бүр хяналт шалгалтыг хийж, сөрөг нөлөөллийг буууруулах талаарх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 онд цэвэрлэх байгууламжийн төслийн талбайд хийгдсэн ажлуудыг доорх фото зургаар харуулав.



Зураг 2. Захиргаа, үйлдвэрийн барилга

“Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам”-ны Завхан аймгийн Улиастай сумын “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төсөл



Зураг 3. Биореакторын барилгын ажил



Зураг 4. Тоног төхөөрөмжийн суурилуулалт хийж буй

“Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам”-ны Завхан аймгийн Улиастай сумын “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төсөл




Зураг 5. Төслийн талбайн өнөөгийн байдал

### 1.7. Төсөл хэрэгжих газарт орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд хийсэн хээрийн судалгаа

Байгаль орчны үнэлгээ, зөвлөх үйлчилгээний “Амин байгаль” ХХК нь уг төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд төлөвлөгөөнд тусгасаны дагуу орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг жилд 3 удаа хийхээр төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөт орчны хяналт шинжилгээний хээрийн судалгааны ажлыг шинээр баригдаж байгаа ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн ойр орчмын газарт 2025 оны 5 дугаар сард, 7 дугаар сард, 10 дугаар сард тус тус хийж, дээж, шинжилгээнүүдийг авч судалгааг явуулсан.

Хээрийн судалгааны явцад уламжлалт мониторингийн цэгүүдээс агаар, хөрс, усны дээж авч шинжилгээнд хамруулан орчны ажиглалт, хэмжилт, зураглал хийж, хяналтын шинжилгээний үр дүнг боловсруулсан.

Ус, хөрс, агаарын химийн задлан шинжилгээ, бохирдолын шинжилгээнүүдийг ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн лаборатори, “Дээж”, “Ланд овнер” зэрэг итгэмжлэгдсэн хөрс, усны төв лабораториудад тус тус шинжлүүлсэн. Мөн Завхан аймгийн Ус цаг уур, орчны орчны шинжилгээний төв байгаль орчны шинжилгээний лабораторийн агаарын чанарын инженер Балжинням нар тус тус оролцов.




Зураг 6. Орчны хяналт шинжилгээ хийсэн цэгүүдийн байршлын зураг /Arcgis 10.8/

“Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам”-ны Завхан аймгийн Улиастай сумын “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төсөл

### Агаарын чанарын хяналтын шинжилгээний судалгаа, үр дүнгүүд

Агаарын чанарын судалгааг 2025 оны 5 дугаар сард, 7 дугаар сард, 10 дугаар сард тус тус 1 цэгт хийж, агаарын чанарын үндсэн үзүүлэлтүүд болон Азотын давхар исэл- $\text{NO}_2$  мкг/м<sup>3</sup>, Хүхэрлэг хий  $\text{SO}_2$  мкг/м<sup>3</sup>, Нийт тоос мкг/м<sup>3</sup> зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Үүнд: Завхан аймгийн УЦУОШТ-ийн Байгаль орчны шинжилгээний лабораторитой хамтран ажилласан.



Зураг 3. Агаарын шинжилгээ хийсэн газрын байршил /Arcgis 10.8/

Дээж шинжилгээ хийж байх үеийн фото зургийг доор оруулав.



Зураг 6. 2025 оны 5, 7, 10 дугаар саруудад агаарын шинжилгээ хийж байх үеийн фото



**“Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам”-ны Завхан аймгийн Улиастай сумын “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төсөл**


**Хүснэгт 1. Агаарт хийсэн хэмжилтийн үр дүнгүүд**

| №                                                         | Шинжилгээний аргын стандартууд | Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж                  | Хүлцэх агууламж MNS 4585:2016 | Шинжилгээний үр дүн |
|-----------------------------------------------------------|--------------------------------|---------------------------------------------------------|-------------------------------|---------------------|
| <b>2025 оны 5 дугаар сард хийсэн шинжилгээний үр дүн</b>  |                                |                                                         |                               |                     |
| 1                                                         | MNS 017-2-5-11:2021            | Азотын давхар исэл-NO <sub>2</sub> , мкг/м <sup>3</sup> | 0.450                         | 0.008               |
| 2                                                         | MNS 017-2-5-12:2021            | Хүхэрлэг хий- SO <sub>2</sub> , мкг/м <sup>3</sup>      | 0.200                         | 1.0                 |
| 3                                                         | MNS 4048-88                    | TSP нийт тоос, мкг/м <sup>3</sup>                       | 0.500                         | 18.0                |
| <b>2025 оны 7 дугаар сард хийсэн шинжилгээний үр дүн</b>  |                                |                                                         |                               |                     |
| 1                                                         | MNS 017-2-5-11:2021            | Азотын давхар исэл-NO <sub>2</sub> , мкг/м <sup>3</sup> | 0.450                         | 49.0                |
| 2                                                         | MNS 017-2-5-12:2021            | Хүхэрлэг хий- SO <sub>2</sub> , мкг/м <sup>3</sup>      | 0.200                         | 3.0                 |
| 3                                                         | MNS 4048-88                    | TSP нийт тоос, мкг/м <sup>3</sup>                       | 0.500                         | 32.0                |
| <b>2025 оны 10 дугаар сард хийсэн шинжилгээний үр дүн</b> |                                |                                                         |                               |                     |
| 1                                                         | MNS 017-2-5-11:2021            | Азотын давхар исэл-NO <sub>2</sub> , мкг/м <sup>3</sup> | 0.450                         | 7.0                 |
| 2                                                         | MNS 017-2-5-12:2021            | Хүхэрлэг хий- SO <sub>2</sub> , мкг/м <sup>3</sup>      | 0.200                         | 5.0                 |
| 3                                                         | MNS 4048-88                    | TSP нийт тоос, мкг/м <sup>3</sup>                       | 0.500                         | 28.0                |

**Агаарын чанарын шинжилгээний дүнгийн харьцуулалт**

| №        | Үзүүлэлт                              | Хэмжих нэгж        | Хүлцэх агууламж (MNS 4585:2016) | 2025.05 | 2025.07 | 2025.10 | Стандарттай харьцуулсан үнэлгээ                                           |
|----------|---------------------------------------|--------------------|---------------------------------|---------|---------|---------|---------------------------------------------------------------------------|
| <b>1</b> | Азотын давхар исэл (NO <sub>2</sub> ) | мкг/м <sup>3</sup> | 0.450                           | 0.008   | 49.0    | 7.0     | ✓ Бүх хугацаанд стандартын хязгаараас <b>доогуур</b> , агаарын чанар сайн |
| <b>2</b> | Хүхэрлэг хий (SO <sub>2</sub> )       | мкг/м <sup>3</sup> | 0.200                           | 1.0     | 3.0     | 5.0     | ✓ Бүх үед стандартын хязгаараас <b>доогуур</b> , агаарын чанар хэвийн     |
| <b>3</b> | Нийт тоос (TSP)                       | мкг/м <sup>3</sup> | 0.500                           | 18.0    | 32.0    | 28.0    | ✓ Бүх үед стандартын хязгаараас <b>доогуур</b> , тоосжилт бага            |





● Улаан тасархай шугам нь **MNS 4585:2025 стандартын хүлцэх хязгаарыг** илэрхийлэх болно.

2025 оны 5, 7, 10 дугаар саруудад хийсэн шинжилгээний үр дүнгээс харахад агаарын чанар хүлцэх хэмжээнд бүрэн нийцэж байна. Үзүүлэлтүүдийн утга улирлын онцлогоос шалтгаалан бага зэрэг хэлбэлзсэн боловч ерөнхийдөө буурах чиг хандлагатай байна. Судалгааны талбайн орчны агаар цэвэр, бохирдол багатай ангилалд хамаарна.

### Усны чанарын хяналтын шинжилгээ, үр дүнгүүд

Завхан аймгийн Улиастай суманд баригдаж буй шинэ цэвэрлэх байгууламжийн байгаль орчны хяналт-шинжилгээний төслийн хүрээнд цаашид технологийн зориулалтаар ашиглах гүний худаг уснаас чанар, найрлагыг судлах зорилгоор судалгааны талбайд 2025 оны 5, 7, 10 дугаар саруудад очиж сорьц авч хяналтын шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэв. Хээрийн судалгаагаар газар дээр нь очиж хэмжилт хийж, усны дээжинд ерөнхий химийн задлан шинжилгээг ШУА-н Газарзүй-геоэкологийн хүрээлэнгийн лабораторид тодорхойлуулж шинжилгээний үр дүнгийн боловсруулалт хийж, харьцуулсан дүгнэлт гаргав.

#### Хээрийн судалгааны арга зүй

Судалгаа хийсэн уст цэгүүдийн химийн задлан шинжилгээг хээрийн нөхцөлд хийхдээ усны температурыг термометрээр, өнгө, үнэр, тунгалаг чанарыг мэдрэхүйн эрхтэний тусламжтайгаар, усны орчинг pH метрээр, цахилгаан дамжуулах чадварыг кондуктометрээр, нийт ууссан эрдэс давсыг TDS метрээр, булингаршлыг турбидиметрийн аргаар тус тус тодорхойлсон болно.

#### Суурин судалгааны арга зүй

Лабораторийн нөхцөлд усны шинжилгээг хийхдээ гидрохимийн практикт өргөн хэрэглэгддэг, мэдрэх чадвар, нарийвчлал сайтай уламжлалт химийн аргаар, амархан хувирамтгай нэгдлүүд болох аммони, нитрит, нитрат, төмөр болон сульфат ионыг спектрометрийн аргаар, исэлдэх чанарыг перманганатын аргаар, натри, калийг тооцооны аргаар, ерөнхий хатуулаг,  $\text{Ca}^{2+}$ ,  $\text{Mg}^{2+}$ -ийг трилонометрийн,  $\text{HCO}_3^-$ ,  $\text{CO}_3^{2-}$ -ийг хүчлийн,  $\text{Cl}^-$ -ийг аргентометрийн аргаар тус тус тодорхойлов.


Хүснэгт 4. Усны дээж авсан цэгүүдийн байршил


| Д/д | Цэгүүдийн байршил             | Өндөршил-Н, м | Солибцол                             |
|-----|-------------------------------|---------------|--------------------------------------|
| 1   | ЦБ-н талбайд байх гүний худаг | 1740          | N 47° 44' 41.44"<br>E 96° 49' 08.58" |



Гүний худгийн усны шинжилгээний дүнгийн харьцуулалт

| № | Үзүүлэлт                                                                     | Хэмжих нэгж | MNS 0900:2018 хүлцэх агууламж | 2025.05 | 2025.07 | 2025.10 | Дүгнэлт                               |
|---|------------------------------------------------------------------------------|-------------|-------------------------------|---------|---------|---------|---------------------------------------|
| 1 | Нийт катион ( $\text{Ca}^{2+} + \text{Mg}^{2+} + \text{Na}^+ + \text{K}^+$ ) | мг/л        | $\leq 1000$                   | 33.8    | 34.76   | 28.0    | ✓ Хүлцэх хэмжээнд, дунд эрдэсжилттэй  |
| 2 | Нийт анион ( $\text{Cl}^- + \text{SO}_4^{2-} + \text{HCO}_3^-$ г.м)          | мг/л        | $\leq 1000$                   | 95.2    | 104.69  | 65.1    | ✓ Хүлцэх хэмжээнд, буурах чиглэлтэй   |
| 3 | Нийт хатуулаг ( $\text{CaCO}_3$ -ээр)                                        | мг-экв/л    | $\leq 7-10$                   | 7.1     | 7.58    | 7.4     | ○ Дээд хязгаар орчимд, хатуулагтай ус |
| 4 | TDS (нийт эрдэсжилт)                                                         | мг/л        | $\leq 1000$                   | 150.1   | 154.2   | 107.7   | ✓ Хүлцэх хэмжээнд, буурах хандлагатай |






Усны бүх үзүүлэлт MNS 0900:2018 стандартын шаардлагад бүрэн нийцэж, 2025 оны 10 сард буурах хандлагатай байна.

### Хөрсний хяналт шинжилгээний үр дүнгүүд

Цэвэрлэх байгууламж барьж буй талбайн газрын гадарга барилгын талбайн хилээр ургамлан нөмрөггүй халцгай, барилгажаагүй хэсгээр ургамлан нөмрөг бүрхэц арвин, газар ашиглалтын эвдрэл бага, аллювийн хайргархаг ширэгт хөрс тархсан байна. Энэ талбайд Монгол орны хөрсний ангиллаар голын татмын хөрсний хэвшинжид багтах Аллювын хайргархаг ба хайргархаг ширэгт хөрс зонхилон тархсан байна.



Зураг 6. ЦБ-н талбай орчим хөрсний дээж авсан цэгүүд

**“Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам”-ны Завхан аймгийн Улиастай сумын “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төсөл**

**Хүснэгт 2. Хөрсний дээж авсан цэгүүдийн байршил**


| Д/д | Цэгүүдийн байршил                     | Өндөршил-Н, м | Солибцол                             |
|-----|---------------------------------------|---------------|--------------------------------------|
| 1   | ЦБ-н талбайн зүүн урд талаас /Дээж-1/ | 1738          | N 47° 44' 38.61"<br>E 96° 49' 08.99" |
| 2   | ЦБ-н талбайн хашаан дотор/Дээж-2/     | 1740          | N 47° 44' 40.86"<br>E 96° 49' 08.29" |
| 3   | Эрүүл ахуй /Дээж-3/                   | 1739          | N47° 44' 40.96<br>E 96° 49' 08.40"   |




**Зураг 9. Хөрсний дээж авч буй үеийн фото**

| Металл           | Хүлцэх агууламж (мг/кг) | 2025.05 | 2025.07 | 2025.10 | Дүгнэлт                               |
|------------------|-------------------------|---------|---------|---------|---------------------------------------|
| Ni (Никель)      | ≤ 150                   | 13.15   | 13.6    | 50.9    | Бүгд хүлцэх хэмжээнд, бохирдолгүй     |
| Cd (Кадми)       | ≤ 3.0                   | -       | -       | -       | Илрээгүй                              |
| Pb (Хар тугалга) | ≤ 100                   | 8.52    | 8.2     | 41.8    | Хүлцэх хэмжээнд, нэмэгдэх хандлагатай |
| Cu (Зэс)         | ≤ 100                   | 19.19   | 22.9    | 22.9    | Хэвийн, тогтвортой                    |
| Zn (Цайр)        | ≤ 300                   | 91.26   | 72.4    | 84.6    | Хүлцэх хэмжээнд, зуны улиралд өссөн   |
| Cr (Хром)        | ≤ 150                   | 11.55   | 60.3    | 33.1    | Хэвийн, бага зэргийн өсөлттэй         |

“Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам”-ны Завхан аймгийн Улиастай сумын “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төсөл



Улирлын өөрчлөлт — бүх металлын агууламж 5 → 7 → 10 сард өсөх хандлагатай ч стандартын хязгаараас доогуур байна.



Энэ графикаас харахад бүх хүнд металлын (Ni, Pb, Cu, Zn, Cr) агууламж улирлаар өөрчлөгдөж байгаа ч MNS 5850:2019 стандартын хүлцэх агууламжаас (улаан тасархай шугамаар тэмдэглэсэн) бага байна.

### Хөрсний эрүүл ахуй

Хөрсний эрүүл ахуйн дээжийг цэвэрлэх байгууламжийн барилга болон ажилчдын ашиглаж байгаа ариун цэврийн газрын ойролцоогоос авсан.

Солбицол нь N47° 44' 40.96" E 96° 49' 08.40", үнэмлэхүй өндөр 1740 м.



Зураг 9. Хөрсний эрүүл ахуйн дээжлэлт

### Хүснэгт 3. Хөрсний эрүүл ахуй

| Гүн,<br>см | Нянгийн тоо        | Гэдэсний савханцарын титр (E.Coli) |                 | Анаэробын титр (C.perfringens) |                 |
|------------|--------------------|------------------------------------|-----------------|--------------------------------|-----------------|
| 0-5        | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу                 | Бохирдлын зэрэг | Шинжилгээний хариу             | Бохирдлын зэрэг |
|            | $3.1 \times 10^5$  | $\geq 0.1$                         | 1               | $\geq 0.1$                     | 1               |

- **Нянгийн тоо ( $3.1 \times 10^5$  CFU/г):** Хөрсөнд бичил биетний идэвх өндөр, органик бохирдол байгааг илтгэнэ.
- **E. coli титр  $\geq 0.1$ :** Энэ нь хүний болон амьтны ялгадас гаралтай бохирдлын үзүүлэлт бөгөөд **I зэрэг бохирдолтой** гэж үнэлэгдэж байна.
- **Clostridium perfringens ( $\geq 0.1$ ):** Мөн адил бохирдлын **I зэрэг** илрүүлж байна. Энэ нь бохирдлын тогтвортой эх үүсвэр болохыг харуулна.

### Хүснэгт 4. Хөрсний бичил амь судлалын үзүүлэлтийн бохирдлын үнэлгээ MNS:ISO3297:2019

| Хөрсний бохирдлын түвшин | Гэдэсний савханцар илрэх хамгийн бага хэмжээ (колититр) | Агааргүйтэн нян илрэх хамгийн бага хэмжээ (Перфрингенс титр) | Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян (салмонелла) (1 гр-д) |
|--------------------------|---------------------------------------------------------|--------------------------------------------------------------|---------------------------------------------------------|
| <b>Цэвэр</b>             | $\geq 1.0$                                              | $\geq 1.0$                                                   | <b>илрэхгүй</b>                                         |
| Бага бохирдолтой         | 0.01                                                    | 0.01                                                         | илрэхгүй                                                |
| Дунд бохирдолтой         | 0.001                                                   | 0.001                                                        | илрэхгүй                                                |
| Их бохирдолтой           | $\leq 0.0001$                                           | $\leq 0.0001$                                                | илрэхгүй                                                |

Шинжилгээний дүнгээр 2025 оны 7 дугаар сард хийсэн шинжилгээгээр гэдэсний савханцар илрэх хамгийн бага хэмжээ (колититр) 1 буюу бохирдлын 1 дүгээр зэрэг, агааргүйтэн нян илрэх хамгийн бага хэмжээ (перфрингенс титр) 1 буюу бохирдлын 1 дүгээр зэрэг байсан. 2025 оны 5 дугаар сар болон 10 дугаар сард хийсэн шинжилгээнд гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян (салмонелла) илрээгүй буюу цэвэр байсан. Дээжний хариуг хавсралтаар оруулав.

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| №                                                                                      | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд                                                                                                                                   | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ                                                                                                           | Төлөвлөгөөний биелэлт                                                                                                                                                                                                       | Баримтлах эрхзүйн баримт бичиг                                                                                                                                                                                         |
|----------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар</b>                        |                                                                                                                                                                        |                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                        |
| 1.                                                                                     | Ахуйн цэвэрлэх байгууламж барих, барилгын материал зөөвөрлөх үйл ажиллагаанаас тоосжилт үүсч, агаарын чанарт сөргөөр нөлөөлөх                                          | Барилгын ажлын талбайд усны машин ашиглан тоосжилт үүсэх замуудыг дулааны улиралд услах, чийглэх, замыг дагтаршуулах                                      | Барилгын газар шорооны ажлын үед машин техникийн механик хөдөлгөөнөөс үүссэн тоосжилтийг тухай бүрд усаар шүршиж дарж байсан.                                                                                               | MNS 4585:2016<br>Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага                                                                                                                                                            |
| 2.                                                                                     | Тээврийн хэрэгсэл, бусад машин механизмын хөдөлгүүрийн шаталтаас үүсэх NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CO зэрэг хий нь бичил орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлөх | Барилгын ажилд ашиглагдаж буй бүх төрлийн машин механизм, дизель станцад үзлэг оношилгоо засварыг тогтмол хийж, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэх | Тээврийн хэрэгслүүдийг жил бүр оношилгоо, үйлчилгээнд бүрэн хамруулдаг.                                                                                                                                                     | MNS 5013:2003<br>Бензин хөдөлгүүртэй автомашин – утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ<br>MNS 5014:2003<br>Дизель хөдөлгүүртэй автомашин - Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ            |
| <b>Хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар</b> |                                                                                                                                                                        |                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                        |
| 3.                                                                                     | Ахуйн болон хатуу хог хаягдлаар хөрс бохирдох                                                                                                                          | Бүх төрлийн хатуу болон ахуйн хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал түр хадгалах цэгийн ойр орчин халдваргүйжүүлэлт тогтмол хийж байх                   | Барилгын ажлын талбай, ажилчдын байранд хог хаягдлын түр цэг байрлуулан тухай бүрд аймгийн нэгдсэн хогийн цэг рүү ачуулдаг.                                                                                                 | “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах журам”<br>Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг |
| 4.                                                                                     | Ахуйн хаягдал, шатах, тослох материал алдагдах, хаягдлыг зайлуулах үед хөрс бохирдох                                                                                   | Автомашинь зогсоол, явган хүний зам, хог хаягдлын цэг зэрэг талбайг хатуу хучилттай болгох газрын гадарга, хөрс бохирдохоос сэргийлэх                     | Барилгын газар шорооны ажлын үед машин техникийн механик хөдөлгөөнөөс үүссэн тоосжилтийг тухай бүрд усаар шүршиж дарж байсан бөгөөд талбай доторх авто болон явган хүний зам талбайг стандартын дагуу хийж гүйцэтгэж байна. |                                                                                                                                                                                                                        |

**“Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам”-ны Завхан аймгийн Улиастай сумын “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төсөл**

|                                                                                     |                                                                                                            |                                                                                |                                                                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                 |
|-------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                     |                                                                                                            |                                                                                |                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                 |
| <b>Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар</b> |                                                                                                            |                                                                                |                                                                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                 |
| 5.                                                                                  | Унд-ахуйн усны эх үүсвэр болох гүний худагт ариун цэврийн болон хамгаалалтын бүс тогтоогоогүйгээс бохирдох | Гүний худгийн эргэн тойронд ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож хашаажуулах | <p>Цэвэрлэх байгууламжийн технологийн хэрэглээнд ашиглах гүний худгийг битүүмжилж, захиргаа, үйлдвэрийн барила руу холбох шугам хоолойн ажил хийгдэж байна.</p>  | <p>БОНХАЖС, БХБСайдын 2015 оны А-230/127 тоот “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”</p> <p>Усны тухай хууль 3-бүлгийн 22-р зүйл ба бусад зүйл, бусад хууль, журам, стандарт</p> |
| <b>Биелэлт</b>                                                                      |                                                                                                            |                                                                                | <b>100%</b>                                                                                                                                                                                                                                          | <b>-</b>                                                                                                                                                                                                                                                        |

“Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам”-ны Завхан аймгийн Улиастай сумын “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төсөл

### 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн барилга, тоног төхөөрөмжийн угсралтын ажил, орчны тохижилтын ажил нь 2025 онд дуусаж байгаа бөгөөд төслийн ТЭЗҮ, БОННҮ, зураг төсөлд төлөвлөгдсөн 1526 м<sup>2</sup> талбайд хийх ногоон байгууламжийн /зүлэгжүүлэх, мод суулгац тарих/ ажлыг хаврын улиралд хийхээр төлөвлөсөн. Одоогийн байдлаар авто болон явган хүний зам, гэрэлтүүлэг, амрах сүүдрэвч зэрэг тохижилтын ажлыг хийж байна.



Зураг 10. Гадна тохижилтийн ажил хийгдэж байгаа нь

### 4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд түүх, соёлын өв дурсгалууд илрээгүй болно.

## 5. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө                                                                                       | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ                                                                                                                            | Төлөвлөгөөний биелэлт                                                                                                                                                                                                              | Баримтлах стандарт, аргачлал                                                                                                                                    |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Аянга буух, цахилгаан хэрэгслийн гэмтэл, хэт халалт зэргээс үүдэн гал түймэр гарах                                     | Галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойг зохих газруудад байрлуулах, галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойд зөвшөөрөгдсөн тэмдэг тавьсан байх | Цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн ажил дуусах үед галын дохиолол, гал унтраагуур хийнэ.                                                                                                                                    | Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017 он<br>Галын аюулгүй байдлын тухай хууль<br>Барилга байгууламжийн аянга хамгаалалтын зураг төсөл зохиох заавар БД 43-103-08 |
|                                                                                                                        | Аянга газардуулагчийг ойролцоох өндөрлөг газруудад суурилуулж өгөх, цахилгаан дамжуулах, цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулсан байх      | Аянга газардуулагчийг КТП-н ойролцоо суурилуулж, цахилгаан дамжуулах, цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг хийж гүйцэтгэсэн.                                                                                                       |                                                                                                                                                                 |
| Ажиллагсадын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дэглэм зөрчигдсөнөөс хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй | Ажилчдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын хувцас хэрэгслээр хангах                                                                                                   |                                                                                                                                                |                                                                                                                                                                 |
|                                                                                                                        |                                                                                                                                                                       | MNS 4968: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага<br>ХАБЭА-н тухай хуулийн 15-р зүйлд ажилтныг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах тухай заасаны дагуу хөдөлмөр хамгааллын хувцасаар хангах |                                                                                                                                                                 |

**“Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам”-ны Завхан аймгийн Улиастай сумын “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төсөл**

|                |                                                                                |                                                                                                                             |          |
|----------------|--------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------|
|                |                                                                                |                                          |          |
|                | Анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангасан байх | Ажиллагсдад зориулан анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг бэлэн байлгаж аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. |          |
| <b>Биелэлт</b> |                                                                                | <b>100%</b>                                                                                                                 | <b>-</b> |

## 6. ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ХИЙГДСЭН АЖИЛ

| Д.д | Гол ба болзошгүй сөрөг нөлөө                                                                   | Хийгдэх ажил                                                                                                                       | Хариуца х эзэн             | Төлөвлөгөөний биелэлт                                                                                                                                                                               | Баримтлах эрх зүйн баримт бичиг                                          |
|-----|------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------|
| 1.  | Хог хаягдлын цэг, хог хаягдал ангилан ялгах талбай, агуулахын орчимд бохирдол үүсгэж болзошгүй | Хог хаягдлын цэгт ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх                                                                       | Хариуца<br>Талбайн инженер | Хог хаягдал ангилан ялгах цэгийн орчинд сард 1 удаа ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийж байна.                                                                                                      | MNS 5344:2003. Ахуйн хог хаягдал. Тээвэрлэлт, ангилал, ерөнхий шаардлага |
|     |                                                                                                | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, хог хаягдал зайлуулах гэрээг зохих байгууллагатай хийж, гэрээний дагуу зайлуулж байх |                            | Барилгын ажлын үед ашиглах түр хог хаягдлын цэг болон бие засах газрыг байгуулсан. Ахуйн болон барилгаас үүсэн хог хаягдлыг тухай бүрт нь хог ачилтын газраар ачуулж, хог хаягдлын цэгт хүргүүлдэг. | Хог хаягдлын тухай хууль 2017 он                                         |

“Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам”-ны Завхан аймгийн Улиастай сумын “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төсөл

|         |  |  |  |                                                                                     |  |
|---------|--|--|--|-------------------------------------------------------------------------------------|--|
|         |  |  |  |  |  |
| Биелэлт |  |  |  | 100%                                                                                |  |

7. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

| Орчны хяналт шинжилгээ хийх хөтөлбөр |                                                                                                                                                                                                                             |                                    |                                  |                       |                          |                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                               |
|--------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------|----------------------------------|-----------------------|--------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Байгаль орчны бүрэлдэхүүн            | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт                                                                                                                                                                                              | Хугацаа ба давтамж                 | Хяналт шинжилгээний ажлын хэмжээ | Нэгжийн өртөг мян.төг | 2025 оны зардал, мян.төг | Тайлбар                                                                                                                                                                                                                                 | Баримтлах стандарт ба арга аргачлал                                                                                                                                                                           |
| Агаар                                | Агаар дахь хийн агууламж<br>CO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , O <sub>3</sub> , CH <sub>4</sub> , NH <sub>3</sub>                                                                                        | Жилд 3 удаа<br>(5,7,10 саруудад)   | Төслийн талбайд (Жилд * 3 удаа)  | 50.0                  | 200.0                    | <p>Завхан аймгийн Ус цаг уур, орчны орчны шинжилгээний төв байгаль орчны шинжилгээний лабораторид шинжлүүлсэн. Хавсралтаар дэлгэрэнгүй оруулав.</p>  | Агаараас сорьц авах, агаар дахь хүхэрлэг хийн агууламжийг тодорхойлох, агаар дахь азотын давхар ислийн агууламжийг Тодорхойлох, Агаар мандал, сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS: 3384-82               |
| Ус                                   | pH, Нийт хатуулаг (CaCO <sub>3</sub> ), Ca, Mg, Na, K, Fe, NH <sub>4</sub> , SO <sub>4</sub> , NO <sub>2</sub> , NO <sub>3</sub> , CO <sub>3</sub> , HCO <sub>3</sub> , Ni-ийн агууламж, амт, үнэр, өнгө, тунгалаг, тунадас | Жилд 3 удаа<br>(5, 7, 10-саруудад) | Гүний худаг                      | 47.0                  | 188.0                    | <p>ШУА-н Газарзүй Гео-экологийн хүрээлэнгийн хөрсний лаборатори Завхан аймгийн Ус цаг уур, орчны орчны шинжилгээний төв байгаль орчны шинжилгээний лабораторид шинжлүүлсэн. Хавсралтаар дэлгэрэнгүй оруулав.</p>                        | MNS ISO 5665-5:2001 “Усны чанар. Ундны уснаас дээж авах стандарт. “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” |



## 8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

